

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ламжав	Дугаар	L276
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Арбулаг сум
Төрсөн газар	Арбулаг сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жалханз хутагтын хүрээ, Хүйсийн хурал	Сүм хийдийн дугаар	ХӨАБ 009, ХӨАБ 008
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Жалханз хутагтын хүрээ, Хүйсийн хурал

Мөнхбат: За энэ түүрийг одоо газрын ором, байдлаас нь харахад одоогоос лавтай хоёр зуугаад жилийн цаад жилийн одоо үед хамаарагдах ийм түүр болов уу гэсэн таамаглалыг дэвшүүлж байгаа. За мөн нөгөө талаар энэ тухайн үедээ одоо нэлээн том олон сүм дугантай бурхан номын нэлээн томоохон газар байжээ гэдэг нь энд үлдээсэн энэ сүм дуганы түүриудаас харагдаж байна. Жишээлбэл энд одоо нүдэн баримжаагаар арав гаруй том жижиг дуганы түүр харагдаж байна. Харин зүгээр энэ сүм дуганы мөрүүд бол олон жилийн энэ хугацаанд газрын хөрснөөсөө бараг мэдэхгүй шахам болсон ийм байдалтай байна.

Ламжав: Үгүй ээ, одоо далаад оны үеэс эхэлж энийг сонирхсон. Би урьд нь сонирхож байгаагүй. Энэ бол Жалханз хутагтын хийд байсан юм гэж үг байдаг. Уг хийдийг энд байхад тарваган тахал өвчин гарсан учраас эндээс нүүсэн гэдэг. Чухам эндээс нүүхэд Лүнгийн амны тэнд Майхны өвөрт Бичигтийн тохой гэдэг дээр энэ хийд очиж буусан байх аа гэж санагддаг. Тийм юм бол одоо миний хувийн таамаглал байдаг. Учир гэвэл Жалханз хутагтын албат тэр хийдийн жаягдал, бас сахиулагч нарын нэртэй холбоотой одоо газар болоод гарсан байдаг юм, Лүнгийн аманд. Эндээс цаашаагаа Баянголд очсон гэдэг тийм яриа байдаг. Мөн хэлэхдээ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баянголоосоо өвгөн хийд дээр буусан гэдэг.Тэнд хэдэн жил болсон гэдэг үг байдаг. Хамгийн сүүлчийнх нь л гучин найман онд одооны байгаа ганц суваргатай гурван модтой туурь бий.Энийг Түргэхийн хотхон гэдэг.Тэгээд Түргэхийн хотхон дээрээс утсан гэдэг тийм л яриаг би дуулж, одоо хэлэх байна. Энэ тэгээд хийд анх, Жалханз хутагтын хийд байгуулагдахад шинжийн асуудал яригдсан.Энэ хийд байгаа газрыг хэвтсэн туулай шинжтэй газар гэж ярьсан.Шинжээч бол тэгж хэлсэн.Тэгэхлээр энэ дээр байж байгаа энэ том хүрээ хийд болвол хярчихсан бүргэдийн шинжтэй байна гэж. Хярчихсан бүргэд байгаа газар бол туулай бол хэзээ ч босж гүйхгүй.Тийм учраас энд оршин тогтнож болох юм гэсэн таамаг хийсэн гэдэг.Тийм үг бий.Мөн Их-Уулын, энэ хойд талын уулыг Их-Уул гэж бий.Их-Уулын адаг араг шиг, савар шиг хадтай гэдэг тийм яриа гарсан байна лээ гэж ярьдаг юм.Тэгээд шинжээч нар хэлэхэд одоо өглөө хуралдаа очиж яваа лам нар нь очиж яваа шинжтэй хад гэж, одоо бүхэл бүтэн эгнээ хадыг хуралдаа очиж байгаа лам нарын хэлбэртэй байна гэж. За тэгээд энэ хийдээс зарим лам нар нь, амьд үлдэж чадсан бадарчин нь ингэж Заяын хийд орсон юм гэнэ лээ гэж нэг тийм домог шиг л юм байдаг.Ямар учраас үүссэн нь бол мэдэгдэхгүй.

Мөнхбат: Тэгэхээр одоо энэ та бид хоёрын суугаад харж байгаа энэ туурийн ерөнхий хүрээ, ором туурийг харахад энэ хийд тухайн үедээ нэлээн том хүрээ хийдийн газар байсан нь тодорхой байна.Аа нөгөө талаас энэ манай судалгааны багийн бүртгэлд ороогүй, ялангуяа академич Бямбын Ренчин гуайн нэгтгэсэн мэдээлэлд энэ одоо хийдийн талаар ямар ч одоо мэдээлэл байхгүй байгаа.За мөн нутгийн ардуудын дунд энэ хийдтэй холбоотой ямар нэгэн таамаглал мэдээлэл маш бүрхэг байгаа зэргээс шалтгаалан, улбаалаад үзэхэд энэ хүрээ хийд маань нэлээн эртний, магадгүй одоо хоёр гурван зуугаад жилийн тэртээ түүхийг өгүүлсэн ийм одоо хүрээ хийдийн туурь байжээ гэж үзэж байна.Энэ талаар одоо таны бодол ямар байна?

Ламжав: Энэ талаар таны ярьж байгаатай бол би санал нэг байна, юуны өмнө.Гэхдээ монголын хийдүүд бол, монгол туургатан өөрөө нүүдэлчин улс байдаг учраас монголын сүм хийд бол тийм нүүхэд зориулагдсан, монголын буддын шашны сүм хийдүүд чинь хадаас хэрэглэдэггүй тийм журамтай байлаа гэж одоо талийгаач доктор Майдар тодорхойлсон байдаг.Тэгэхлээр одоо хадаас хэрэглэхгүй дандаа углуурга, ширэлдэсний холбоогоор барьдаг байсан.Энэ болвол хийдээ задлаад нүүхэд эвдрэл гардаггүй, тийм ёстой байсан байна. Тэгэхээр байгалийн тахлын голомт энд бий гэж хэлэх үндэс байхгүй, зүгээр гэхдээ тахал гарсан юм гэнэ лээ гэдэг тийм домог шиг юм л үлдсэн байсан.Аа тэгээд заавал тахал гарсан юм гэнэ лээ гэдгээс биш, ер нь цаашдаа ард иргэд нь одоо нутгаасаа нүүгээд холдох бүрий дээр одоо бариатай хийдүүд нь хойноос нь нүүчихдэг байсанг.Тэр жамаар нүүсэн байхыг бас үгүйсгэх газаргүй.

Мөнхбат: За таньтай санал нэг байна аа, таны энэ манай судалгааны багт өгсөн мэдээлэл монголын түүх соёлын дурсгал цаашлаад 1937 оноос өмнө Монголд үйл ажиллагаа явуулж байсан буддын шашны сүм хийдийн түүхэн товчоо хэмээх судалгааны энэ ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа.Танд баярлалаа.

Хүйсийн хүрээ

Мөнхбат: За манай судалгааны баг Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг, Арбулаг сумын зургадугаар багийн нутаг Хүйсийн булаг хэмээх газар ирээд байна. Ингээд энэ Хүйсийн булаг хэмээх газар шашин номын үйл

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ажиллагаа явуулж байсан Хүйсийн хүрээ гэж нэрлэгдсэн энэ хүрээний туурин дээр ирээд байна. За тэгэхээр энэ хүрээний үүсэл, хөгжил одоо шашин номын ямар үйл ажиллагаа явуулж байсан, за хэд орчим ламтай байсан, энэ хүрээний одоо мөхөл, хүрээ нураагдсан энэ тухай тус Арбулаг сумын өндөр настан зурхай судлаач Ламжав багштай ярилцлага хийх гэж байна.

Ламжав: Тэгэхээр энэ хийдийг анхан усгаж эхэлж байсан цаг үе нь бол 1937 оноос эхэлж лам нарыг нь барьж устгахаасаа л эхэлсэн, угаасаа. Гучин долоон онд нэг хоёр тоогоор барьдаг байсан. Аа тэгээд гучин найман он гэхэд нийтээр нь хоморголон баривчилсан. Ингэж барьсан, би тэгэхэд найман настай байсан.

Мөнхбат: Та түрүүн яриандаа цухас дурдсан. Эндээс дөч, тавиад км-ын зайтай орших хурал хураач гэдэг газар анчид, гөрөөчид ирж одоо ном, одоо хөдөө байсан ганц ламаар ном хуруулж байсан тэр цаг үеэс тэр явдлаас үүдээд Хүйсийн хүрээний суурь үндэс тавигдсан гэж ярьсан. Энэ талаар та тодруулж ярина уу?

Ламжав: Ерөнхийдөө одоо анчид хөдөө айл хотонд байсан ганц ламаар ангийн сан тавиулах мэтийн юмыг хийдэг байсан байгаа юм. Аа тэгээд сүүлдээ жил бүрийн энэ нь давтамжтай байснаа хожим нь ер нь хийдтэй болвол ямар арга юм байна, байх вэ гэж ярьцгаасан гэдэг. Тийм яриа байдаг. Тэгээд хийдтэй больё гэхэд ямар сахиус тахих вэ гэж тэр сангийн лам асуусан тэгэхэд мэдэх хүн байхгүй байх юм л даа. Тэгээд нэг нь одоо ангийн нэг хүн хутганыхаа хэтнээс би нэг ийм зураг олсон юм, бодвол бурхны зураг байх л гэж боддог юм гээд даавуунд эвхээстэй одоо долоон найман см-ийн зураг, тэр зургийг лам нь үзээд энэ чинь Цагаан сахиусны зураг л байна гээд тэгвэл Цагаан сахиус тахих юм уу та нар гэж хэлсэн. Үгүй ээ тэгвэл яадаг юм, тэгвэл яасан юм гэдэг дээрээ хүрсэн. Тэгээд Хурал хураач гэдэг газар анхан Цагаан сахиус хүрсэн байдаг гэж байгаа. Тэнд бол нэг гэр л байсан. Эндээс тавиад км-ын зайтай газар. Хожим нь тэгээд тэндээсээ наашаа нүүж энэ адуун чулууны үзүүр гэдэг газар одоо туурин дээрээ, энэ гэрийн цаад талд бий. Тэндээ нэг цөөхөөн жил болсон. Энэнээсээ хойшоо дараад нь энэ Хүйсийн булаг гэдэг газар ирж энд...

Мөнхбат: Одоо бид нарын энэ зогсож байгаа...?

Ламжав: Одоо бид нарын энэ зогсож байгаа энэ дээр ирсэн. Ийм л юм болсон юм гэнэ лээ. Одоо болвол тэр Давилуугийн энгэр гэдэг тэрэн дээр байх ёстой гэж байгаа юм. Тэгсэн одоо хөсөг андуураад энэ дээр буучихсан учраас хамаг юм нь гэрийн мод нь буучихсан, дахиж нүүгээгүй. Тэгээд эндээсээ гучин найман онд утсан. Гучин найман онд болвол энэ бол эзгүй үлдсэн байсан. Лам нарын хашаа дуган сүмүүд нь бол цөмөөрөө тийм ямар ч эзгүй, чимээ ч байхгүй тийм байдаг байсан. Гучин есөн онд дуганы дээвэр нурж дотор талаасаа баганууд нь харагдаж байдаг байсан. Тэгээд л дөч, дөчин нэгэн он хоёрын хооронд л бүр мөсөн утсан.

Мөнхбат: За мөн та бид хоёр түрүүн танилцаад энэ туурин дээр хэмжилт хийгээд явж байх хоорондоо бас одоо таны хүүчийг сонсож байхад энэ хийдийн маань энэ ойр орчмын ууланд, маанийн зургаан үсгийг модоор, чулуун дэр сийлж одоо мөн зарим бурхан багшийн хөргийг хадан дээр зосоор зурж үлдээсэн ийм дурсгалууд цөөнгүй байсан тухай ярьсан. Тэгээд одоо харин харамсалтай нь өнөөдөр тэр дурсгалууд бүгд устаад, эвдээд үгүй брөлж байсан тухай өгүүлж байсныг санаж байна. Тэгэхээр та энэ тухайгаа манай бичлэгт ярианд оруулж өгнө үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ламжав:Энд бол бурхан багшийн дүрийг хадны хөмөр дотор сийлээд урлачихсан байдаг юм.Гэхдээ бас зохих хэмжээгээр зарим газрын эд ангийг эвдэж гэмтээсэн байх боловч ерөнхийдөө бол бүтнээрээ үлдсэн.Аа тэрэн дээр хадан дээр бичсэн, зосоор бичсэн бичиг, дарам , хум, хэрээ гэх мэтийн үсэг бол одоо байгаа. Аа бусад маанинууд бол зарим нь мод маани, зарим нь гантигаар хийсэн, гантиг маанинуудыг одоо бүгдийг нь хэмх цохисон одоо гантигийн хагархай байдаг.Модон маани бол үлдээгүй.Энэ бол дөрвөн газар, дөрвөн зүгт маани нь байж байсан.Ганцхан Хонгостын дөрөлж дээр байж байгаа хавтгай чулуу шиг, хаанаас ирсэн чулуу нь мэдэгдэхгүй, нэлээн байгалийн өвөрмөц чулуу олсон.Тэрэн дээр маани байсан, Төвд үсгээр бичсэн маани байсан болов чиг баллаж устгасан.Хожмын цагт нэг санасан нь тэр маанийг сэргээлээ гэж бичсэн боловч тэр нь бүрэн утсан.Ум маани бадми хум гэсэн нь , ум маани бамид хум болчихсон байна гэж одоо миний одоогоос хоёр жилийн өмнө амь үрэгдсэн хүү тэгж уншиж байсан.Үнэхээр чиг ум маани бамид хум гэхихсэн юм.Одоо байж байгаа.

Мөнхбат: За баярлалаа, таньд.